

БАТЛАВ:
БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Б. БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“БАЯНЧУЛУУТ ГАЗАР” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.ЗОЛБАЯР

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-021055 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН “ДЭЛГЭРХААН”
ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5328918/

ХЯНАСАН:
БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Д. ДАВААСҮРЭН

2024 он

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр.....	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага	3
1.3. Төслийн байршил	3
1.4. Төслийн хүчин чадал, техник технологи.....	5
1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга	5
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл	6
2.2. Газрын гадарга, геоморфологи.....	6
2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг	7
2.4. Гадаргын болон газрын доорх ус	8
2.5. Хөрсөн бүрхэвч.....	10
2.6. Ургамлан нөмрөг	11
2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил	11
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	13
3.1. Төслийн болзошгүй нөлөөллүүд.....	13
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	16
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
АРАВ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	26
АРВАН ГУРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
АРВАН ДӨРӨВ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..	29
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	30
ХАВСРАЛТ.....	31

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил	3
Зураг 2. Агаарын дундаж температур.....	6
Зураг 3. Төслийн талбай орчмын геоморфологи	7
Зураг 4. Газрын гадарга.....	7
Зураг 5. Төслийн талбай орчмын геологийн тогтоц.....	8
Зураг 6. Төсөл хэрэгжих орчны топо зураг	9
Зураг 7. Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт	10
Зураг 8. Төслийн талба орчмын хөрсөн бүрхэвч.....	10
Зураг 9. Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг	11
Зураг 10. Дотоодын нийт бүтээгдэхүүний бүтэц.....	12

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд	3
Хүснэгт 2. Төсөл хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, түүний үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь	13
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	20
Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
Хүснэгт 6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	27
Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ.....	28
Хүснэгт 10. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	29
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, мян.төг.....	30

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Дэлгэрхааны хайлуур жоншны ордын өмнөд хэсгийг ил, далд аргаар ашиглах” төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: “Баянчулуут газар” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011209059


Регистрийн дугаар: 5328918

Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, 51-5 тоот.

Утас: 99118887

1.3. Төслийн байршил

“Баянчулуут газар” ХХК-ийн эзэмшиж буй MV-021055 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Дэлгэрхааны орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотоос 340 км зайд Хэнтий аймгийн Батноров сумын нутагт 374.14 гектар талбайг хамран оршино. Төслийн талбайн байршлыг дараах зургаар харуулав.



Зураг 1. Төслийн талбайн байршил

Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицлыг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд

№	Уртраг			Өргөрөг			№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1	111	18	00.75	47	44	14.34	46	111	16	47.24	47	44	31.56
2	111	18	00.75	47	44	51.81	47	111	16	46.96	47	44	31.43
3	111	18	00.35	47	44	51.81	48	111	16	46.79	47	44	31.59
4	111	17	56.42	47	44	55.84	49	111	16	41.41	47	44	29.19
5	111	17	56.12	47	44	55.71	50	111	16	44.03	47	44	26.55

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Уртраг			Өргөрөг			№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
6	111	17	55.96	47	44	55.87	51	111	16	41.3	47	44	25.33
7	111	17	54.50	47	44	55.22	52	111	16	45.12	47	44	21.54
8	111	17	51.28	47	44	58.26	53	111	16	45.4	47	44	21.67
9	111	17	51.00	47	44	58.13	54	111	16	45.57	47	44	21.51
10	111	17	50.83	47	44	58.29	55	111	16	49.94	47	44	23.53
11	111	17	48.76	47	44	57.34	56	111	16	53.59	47	44	19.99
12	111	17	50.58	47	44	55.36	57	111	16	53.87	47	44	20.12
13	111	17	46.92	47	44	53.82	58	111	16	54.04	47	44	19.96
14	111	17	47.35	47	44	53.36	59	111	17	4.59	47	44	24.73
15	111	17	44.64	47	44	51.96	60	111	17	8.91	47	44	20.63
16	111	17	45.51	47	44	51.23	61	111	17	9.2	47	44	20.77
17	111	17	43.73	47	44	50.46	62	111	17	9.36	47	44	20.60
18	111	17	46.02	47	44	48.22	63	111	17	19.1	47	44	25.19
19	111	17	40.35	47	44	45.58	64	111	17	23.03	47	44	21.44
20	111	17	41.12	47	44	44.94	65	111	17	23.31	47	44	21.57
21	111	17	38.22	47	44	43.54	66	111	17	23.48	47	44	21.41
22	111	17	39.22	47	44	42.55	67	111	17	31.75	47	44	25.22
23	111	17	35.89	47	44	40.97	68	111	17	29.09	47	44	27.87
24	111	17	32.73	47	44	43.92	69	111	17	32.99	47	44	29.75
25	111	17	32.45	47	44	43.79	70	111	17	31.89	47	44	30.68
26	111	17	32.27	47	44	43.95	71	111	17	37.77	47	44	33.48
27	111	17	29.05	47	44	42.00	72	111	17	39.32	47	44	32.14
28	111	17	33.1	47	44	38.51	73	111	17	39.59	47	44	32.27
29	111	17	26.36	47	44	35.35	74	111	17	39.77	47	44	32.11
30	111	17	22.91	47	44	38.58	75	111	17	54.2	47	44	38.95
31	111	17	22.63	47	44	38.45	76	111	17	52.14	47	44	40.74
32	111	17	22.45	47	44	38.61	77	111	17	54.56	47	44	41.89
33	111	17	19.79	47	44	37.31	78	111	17	52.69	47	44	43.67
34	111	17	18.77	47	44	38.22	79	111	17	57.02	47	44	45.73
35	111	17	18.5	47	44	38.09	80	111	17	55.03	47	44	47.63
36	111	17	18.32	47	44	38.25	81	111	17	57.87	47	44	49.23
37	111	17	07.40	47	44	33.21	82	111	17	57.54	47	44	50.14
38	111	17	06.18	47	44	34.43	83	111	18	0.3	47	44	51.21
39	111	17	05.89	47	44	34.30	84	111	18	0.3	47	44	29.81
40	111	17	05.73	47	44	34.46	85	111	18	0.75	47	44	29.81
41	111	17	01.4	47	44	32.54	86	111	18	0.75	47	43	55.17
42	111	17	0.37	47	44	33.68	87	111	16	22.6	47	43	55.17
43	111	17	0.07	47	44	33.54	88	111	16	22.6	47	44	55.84
44	111	16	59.92	47	44	33.71	89	111	17	17.74	47	44	55.84
45	111	16	49.76	47	44	29.16	90	111	17	17.74	47	45	14.34

1.4. Төслийн хүчин чадал, техник технологи

1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга

Ордын тодорхойлолт: XV-019573 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд өмнөх судалгаагаар 143 цооног, 42 сувгийн ажил хамаарагдаж байгаа бөгөөд нийт өрөмдлөгийн ажлын хэмжээ нь 31655.8 т/м. 2016 оны 10 сард өмнөх судалгааны ажлыг бататгах зорилгоор талбайн зүүн хэсэгт орших хүдрийн биет 8 болон хүдрийн биет 3/7 ийн мэдээлэлд тулгуурлан 2 ш цооногийг 479.2 т.м хэмжээтэй чөмгөн дээжлэлтэйгээр гүйцэтгэж нөөцийн тодотгол тооцооны тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан байна. Ордын ерөнхий структурт тэнхлэг нь 3/7 дугаар хүдрийн биет ерөнхийдөө зүүн хойш 40° суналтай. Баруун талаас 1 ба 2 –р хүдрийн биет, зүүн талаас нь 5–р хүдрийн биет хязгаарладаг. Ордын зүүн өмнө хэсгээр 6. 8–р хүдрийн биетүүд орж ирдэг.

Ордын геологийн нөөц: Дэлгэрхааны хайлуур жоншны ордын өмнөд хэсэг дэх хайгуулын ажлын үр дүнгийн нөөцийн тооцооны тодотгол тооцооны тайланг хэлэлцсэн ЭБМЗ-ийн 2017 оны 07 сарын 06-ны өдрийн ХХ-12-13 тоот дүгнэлийг үндэслэн гаргасан 2017 оны 10 сарын 16-ны өдрийн Н/89 дугаар бүхий АМГТГ-ын даргын тушаалаар “Тавт” нэртэй ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах жоншны хүдрийн нөөцийг бодитой /В/ зэргээр 368.462 мян.тн-оор, боломжтой /С/ зэргээр 588.755 мян.тн -оор, нийт бодитой болон боломжтой /В+С/ зэргээр 957.218 мян.тн-оор буюу 52.91% агуулга бүхий 506506 тн жоншны нөөц хүлээн авсан байна. Ордын үйлдвэрлэлийн нөөц: Ордын батлагдсан геологийн бодитой болон боломжтой /В+С/ зэргээр 957.218 мян.тн хүдэр бүхий 52.91% агуулгатай 506506 тн жоншны нөөцийг ил, далд аргаар ашиглах явцад хаягдал, бохирдол тооцсон бөгөөд үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ 372.3 мян.тн хүдэр бүхий 49.4%-ийн 184.12 мян.тн жоншны нөөц тооцоологдсон байна.


2024 онд явагдах уулын ажил: 2022 онд ил уурхай №1-ийн нээлт, олборлолтын ажил хийж гүйцэтгэсэн байна. Харин 2023 онд ил уурхайнуудын уулын ажил болон далд уурхайн бэлтгэл ажлуудыг эхлүүлэхээр төлөвлөсөн хэдий ч үйл ажиллагаа явуулаагүй болно. Уурхай жилийн турш ил уурхай 12 цагийн 1 ээлжээр, далд уурхай нь 7 цагийн 3 ээлжээр ажиллах зохион байгуулалттай байна. 2024 онд ил уурхайгаас 43.9 мян.м3 хөрс хуулж 50.36%-ийн агуулгатай 31.3 мян.тонн хайлуур жоншны хүдэр олбрлох бөгөөд далд уурхайн уулын ажлаар 1203 м үндсэн болон бэлтгэл малталт нэвтэрч 6.88 мян.м3 хоосон чулуулаг гарган овоолго үүсгэхээр байна. Нийт 2024 онд ил уурхай болон далд уурхайн малталтаас гарах хөрс 50.72 мян.м3 байна.

2024 оны уулын ажлын батлагдсан төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагааны танилцуулга, төлөвлөгөөг дэлгэрэнгүй тусгагдсан болно.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн болон хоногийн температурын хэлбэлзлэл ихтэй, жилийн дундаж хэм нь -2°C . Хамгийн хүйтэн үе нь 12-р сараас 2 сарын эхэн байдаг ба -40°C хүртэл хүйтэрдэг бөгөөд хамгийн халуун сар нь 7-8-р сар, $+40^{\circ}\text{C}$ хүртэл дулаантай байдаг.



Зураг 2. Агаарын дундаж температур

Жилийн хур тунадасны хэмжээ 200 мм-т хэлбэлздэг ба улирал бүрд харилцан адилгүй буудаг. Үүний 70-85% нь зуны улиралд бороо хэлбэрээр буудаг. Өвөлд 20-60 мм цас ордог ба хөрсний хөлдөлтийн гүн дунджаар 3 м хүртэл, олон жилийн цэвдэг байхгүй. Хаварт бараг тогтмол салхи шуургатай байдаг ба салхины чиглэл голдуу баруун хойноос зүүн урагш, хурд дунджаар 4.7 м/сек гэх боловч зарим үед 15-20 м/сек, үе 20-24 м/сек хүрч хүчтэй цасан болон шороон шуурга тавьдаг.

2.2. Газрын гадарга, геоморфологи


Дэлгэрхаан хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт харьяалагддаг ба Батноров сум, Бэрх тосгоны төвөөс 13 км-т Хэнтийн уулархаг өндөрлөгийн зүүн өмнөд хэсэгт, харьцангуй нам оройтой, бэсрэг уулсын хэсэгт хамаарагдна.

Дэлгэрхааны хайлуур жоншны орд орчмын талбайн нь ихээхэн хэрчигдсэн үлдмэл нам уулс бүхий хэсэгт хамаарч байна.

Төслийн талбайн дийлэнх хэсэг нь далайн түвшнээс дээш +1135-1196 м өргөгдсөн, 40-50 м харьцангуй өндөржилттэй толгодорхог гадаргатай байна.

Тус орд нь олон нуурын хугарлын элэгдлийн бүсэд +1130-ийн түвшинд нутгийнхан сайн мэдэх Цагаанчулуутын худгийн дэргэд байрлана. Хамгийн өндөр цэг нь 1410 м өндөртэй Бэрх уул байна.

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 3. Төслийн талбай орчмын геоморфологи

Талбайн усан хагалбар болох нам уулс, гүвээ нь өргөрөгийн дагуу чиглэлтэй урт, нарийн сунасан тогтоцтой бөгөөд энэ нь тухайн районы тектоник эвдрэлийн чигтэй давхцдаг.



Зураг 4. Газрын гадарга


Төслийн талбай нь физик-газарзүйн хувьд Монголын дорнод талын их мужийн Халхын дундад ба Дарьгангын талархаг муж, Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт хамаарна.

2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг

Дэлгэрхаан хайлуур жоншны орд нь Төв Монголын металлогений региональ бүсийн, Хэнтийн металлогений мужийн, Өмнөд Хэнтийн металлогений бүсийн, Бэрх Түмэнцогтын хүдрийн районд, гидротермаль флюоритын хүдрийн формацийн кварц флюоритийн төрөлд хамрагдана. Ордын геологийн тогтоцод дөрөвдөгчийн хурдас, түрүү палеозойн Хэрлэнгийн

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

бүрдлийн 2-р фазын гранитоидууд, дээд юра-доод цэрдийн суурилаг найрлагатай дайкууд болон янз бүрийн гидротермаль бүрдлүүд агуулсан байна.



Зураг 5. Төслийн талбай орчмын геологийн тогтоц

Дэлгэрхаан орд хойт болон өмнөд хэсгээрээ баруун хойш чиглэлтэй региональ, параллель хагарлуудын бүсээр хязгаарлагдсан түрүү палеозойн боржингийн блокд хамаарна. Дээрх хагарлын бүсэд жижиг тасрал эвдрэлүүд үүссэн. Хагарлын ерөнхий чиглэл зүүн хойш чиглэлтэй ч өргөрөгийн болон уртрагийн дагуу чиглэлтэй ан цавууд нь ойр орших тасрал эвдрэлийн серитэй холбоотой. Тасрал эвдрэлүүдийг 2 системд хувааж болно. Үүний нэг буюу олон тоотой хэсэг нь 60-80° босоо уналтай хагарлууд хамаарна. Мөн 20-40° хэвтээ уналтай. Энэхүү талбайд зөрсөн хагарал, эвдрэл, сунал өөрчлөгдөлт, хүдрийн биетийн зузааны өөрчлөгдөлтүүд тэмдэглэгддэг.


Ордын талбайд харьцангуй их биш 2.5 км² талбайд 8 хүдрийн биет тогтоогдсон, кварц-хайлуур жоншны бие биеээ зүссэн нэг багц судал юм. Ордын ерөнхий структурт тэнхлэг нь 3/7 дугаар хүдрийн биет ерөнхийдөө зүүн хойш 40° суналтай. Баруун талаас 1 ба 2 –р хүдрийн биет, зүүн талаас нь 5–р хүдрийн биет хязгаарладаг. Ордын зүүн өмнө хэсгээр 6. 8–р хүдрийн биетүүд орж ирдэг. Бэрхийн хүдрийн зангилааны бусад ордууд нь үндсэндээ уртрагийн чиглэлтэй хүдэр агуулагч структур зонхилдог. Дэлгэрхаан ордын гурван хүдэр агуулагч систем зүүн хойш, уртраг, өргөрөгийн чиглэлтэй байгаагаас харахад Дэлгэрхаан ордод өргөн хүрээтэй хүдэржилтэд явагдсан байна.

2.4. Гадаргын болон газрын доорх ус

Гадаргын ус. Дэлгэрхааны хайлуур жоншны ордыг ашиглах төслийн талбай нь Хэнтий аймгийн Батнорв сумын нутагт байрлах бөгөөд Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарьлалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

тогтоож өгсөн байдаг бөгөөд тус төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Хэрлэн голын сав газарт хамаарна.




Зураг 6. Төсөл хэрэгжих орчны топо зураг

Төслийн талбай орчим гадаргын усны сүлжээ муу хөгжсөн, төслийн талбайн ойр орчмын 10 километрт байнгын урсацтай гол болон нуур байхгүй. Харин төслийн талбайтай хамгийн ойр орших байнгын урсацтай томоохон гол нь Хэрлэн гол байна. Төслийн талбайн зүүн урдуур 20 километрийн зайтай Хэрлэн гол урсан өнгөрч байгаа юм.

Газрын доорх ус. Төслийн талбайн хэмжээнд геологийн давхарга зүйн ангиллын дагуу газар доорх усны байрлал, хөдөлгөөн, хуримтлагдах нөхцөл, геологи-литологийн бүтэц, тогтоц зэргийг харгалзан дээд дөрөвдөгч-орчин үеийн настай сэвсгэр хурдасны нүх сүвийн ус агуулсан уст давхарга, доод цэрдийн настай зүүнбаянгийн давхаргадасын эх газрын гаралтай тунамал хурдасны нүх сүв-давхраасын ус агуулсан уст давхарга, мезозой палеозойн настай гүний болон бялхмал гарал үүсэлтэй чулуулгийн ан цавын уст бүрдлүүдийг ялгасан.

Төслийн талбайн хэмжээнд нүх сүвийн, нүх сүв-давхраас, ан цав судлын коллекторт агуулагдсан үндсэн 3 төрлийн ус агуулагч үе, давхарга, уст бүрдэл тархсан. Энэ ордын хэмжээнд тархсан газар доорх ус нь ан цавын, ан цав-судлын төрөлд хамаарагдах ба ан цав хагарлын бүсээр болон хуурай сайр, жалгын дагуух хөндийнүүдээр агаарын хур тунадасны нэвчилтээр газар доорх усны үндсэн тэжээл бүрдэнэ. Ордын газар доорх усны харьцангуй өндөр усжилттай хуримтлал нь тектоникийн хагарлуудын бүсэд тохиолдоно. Эдгээр нь Бэрхийн уурхайн хайгуулын үед өрөмдөгдсөн гидрогеологийн цооногуудын үр дүнгээс тодорхой харагдах ба энд цооногийн ундарга нь 1.5 -10.5 м түвшний бууралтанд 5 - 10 л/с байжээ.

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ




Зураг 7. Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт

Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц гэж жил бүр хур тунадасны нэвчилт, гадаргын усны нэвчилт шүүрэлт, хажуугийн урсацын нөлөөгөөр дахин бүрэлдэх боломжтой усны хэмжээг хэлнэ. Төсөл хэрэгжих орчин нь газрын доорх урсацын түвшин 5-10 мм/жилд байна.

2.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь монгол орны хөрсний ангиллаар хээрийн бүлэг хөрсний Хархүрэн хөрсний дэд хэвшинжид багтах Чулуурхаг Хархүрэн, ердийн Хархүрэн, зузаан Хархүрэн хөрснүүд зонхилон тархсан байна.




Зураг 8. Төслийн талба орчмын хөрсөн бүрхэвч

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хархурэн хөрс нь үржил шимийн түвшин дунд зэрэг, бэлчээр болон газар тариаланд зонхилон ашиглагддаг.

2.6. Ургамлан нөмрөг

Ургамлын бүрхэвч муутай, тачир сийрэг өвстэй, энд тэнд алтан харгана, зэрлэг бүйлсийн намхан бутнууд ургасан байдаг, хөндий, хуурай нууруудын захаар дэрс, цөөн тоогоор шагшуурга ургадаг. Ой мод сөөг байхгүй. Амьтны аймаг олон төрөлтэй, араатан амьтдаас чоно, үнэг, хярс, мануул, мэрэгчдээс туулай, цөөн тоогоор тарвага, олон төрөл тооны хулганатай, хэвлээр явагчдаас бамбай толгойт могой, хонин ба могой гүрвэлтэй, жигүүртнээс бүргэд, элээ, тогоруу, харцага, сар, ногтруу, тагтаа, нуур тогтсон үед ангир, нугас, галуу түр байрладаг.



Зураг 9. Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг


2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил

Батноров сум нь баруун талаараа Хэрлэн, баруун хойд талаараа Биндэр хойд талаараа Баян-Адрага, зүүн хойд талаараа Норовлин, зүүн, зүүн урд талаараа Баян-Овоо, Урд баруун урд талаараа Баянхутаг сумдтай хиллэдэг, нийт газар нутгийн хэмжээ 515197 га газар, 496.2 мянган га бэлчээр, 9.2 мянган га хадлангийн талбай 6.4 мянган га ой мод, тариалангийн 2.5 мянган га талбайтай.

Бэрх тосгонд эмнэлэг, шуудан холбоо, цахилгаан станц, дэлгүүр хоршоо, зочид буудал, халуун ус зэрэг нийтийн үйлчилгээний газрууд байдаг. Хүн амын ихэнх нь нүүдлийн мал аж ахуй, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг байна.

Хэнтий аймгийн ДНБ-ний салбарын бүтцийг харвал 2010 оноос хойш сүүлийн жилүүдэд ДНБ-нд эзлэх үйлдвэрлэлийн салбарын хувь нэмэгдэж үйлчилгээ болон хөдөө аж ахуйн салбарын хувь багассан байна.

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 10. Дотоодын нийт бүтээгдэхүүний бүтэц

Тухайн районд хүн ам сийрэг 1 кв.км талбайд 0.2-0.6 хүн ам ноогддог. Хамгийн олон хүнтэй нь Батноров сум, Бэрх тосгон ба 1500-4000 хүн амтай. Зам харилцааны хувьд харьцангуй сайн хөгжсөн. Улаанбаатараас Дэлгэрхаан орд хүртэл 340 км цардмал зам, 80 км сайжруулсан шороон замтай, жилийн аль ч улиралд саадгүй зорчих боломжтой. Төмөр замын хувьд Багануураас 270 км, Бор-Өндөрөөс 270 км зайтай. Бэрх тосгон 110 кВт-ийн өндөр хүчдэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон.

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН
ТОДОРХОЙЛОЛТ**

3.1. Төслийн болзошгүй нөлөөллүүд

Байгалийн нөөцийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, уурхайн олборлолт явуулах үед орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх хэсгийг болон нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчим зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэн төслийг хэрэгжүүлсэнээр байгаль орчны төлөв байдал болон орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар доор үзүүлэв.

Хүснэгт 2. Төсөл хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, түүний үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь

Байгаль орчны үзүүлэлт	шууд	шууд бус	өөрөө зохицуулагдах	богино хугацааны	ург хугацааны	буцаж нөлөөлөх	буцалтгүй нөлөөлөх	хүчтэй	дунд зэрэг	бага зэрэг	
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт											
Газрын дээрхи урсацын өөрчлөлт		x			x		x			x	
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		x			x		x			x	
Гадаргын усны урсацын өөрчлөлт		x			x		x			x	
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x		x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x						
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x		x		x		
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										Нөлөөлөл байхгүй	
2. Байгалийн нөөц, ашиглалт											
Газрын гадаргын нөөц баялаг	x				x		x		x		
Бэлчээрийн байдал	x				x	x			x		
Эрдэс түүхий эдийн нөөц	x			x	x				x		
Эрчим хүчний нөөц	x								x		
3. Байгаль, орчны өөрчлөлт											
Агаарын бохирдол		x		x			x			x	
Ундны усны чанар, хэмжээ	x			x						x	
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x	x		x			
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх										Нөлөөлөл байхгүй	
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x						x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл											
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x	x			
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x			
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										Нөлөөлөл байхгүй	
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										Нөлөөлөл байхгүй	
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										Нөлөөлөл байхгүй	

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	x				x				x	
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	x				x				x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
6. Эдийн засаг, байгаль орчин										
Татварын орлого өөрчлөгдөх	x			x			x		x	
Бүс нутгийн орлого нэмэгдэх	x			x			x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x		x			x		x	
Ажлын байр нэмэгдэх	x			x			x		x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх		x			x				x	
7. Бусад нөлөөлөл										
Хог хаягдлаар хөрс, ус бохирдох		x			x	x			x	
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x		x	
Дүн	19	7	0	8	18	3	15	3	8	14

Эдгээр болзошгүй нөлөөллүүдийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Шууд нөлөөлөл. Болзошгүй нөлөөллийн 19 (20%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Барилга байгууламж барихын тулд хөрс хуулах, хөндийн хуурай сайрын хэмжээ чанарт өөрчлөлт оруулах, геологийн тогтоцыг нь шууд эвдэж өөрчлөх, газарын гадаргын нөөц баялагт хомосдол үүсгэх нэг дор дезель хөдөлгүүртэй олон механизм төвлөрч ажиллах зэргээс шалтгаалж экологийн тухайн орчны системд нөлөөлөх, байгалийн тэнцвэр, унаган төрх байдал, ландшафтад сөрөгөөр нөлөөлөх муу талтай. Гэхдээ төсөл хэрэгжсэнээр орон нутгийн орлого нэмэгдэх, улс орны эдийн засагын сан хөмрөгийг нэмэгдүүлэх зэрэг сайн нөлөөтэй.

Шууд бус нөлөөлөл. Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 7 (7.3%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Нэг дор олон хүнд машин механизм зэрэг ажилхад ду чимээ ихсэх зэрэг нөлөөлөл хамаарч байна. Эдгээрийн дуу чимээний улмаас орой орчмын ан амьтад үргэн дайжих магадлал өндөртэй юм.

Өөрөө зохицуулагдах нөлөөлөл. Төслийн үйл ажиллагаанаас өөрөө зохицуулагдах нөлөөлөл байхгүй байна.

Богино хугацааны нөлөөлөл. Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 1 (4,34%) нь буюу бэлчээрийн байдлын нөлөөлөл богино хугацааны нөлөөлөлд орж байна.

Урт хугацааны нөлөөлөл. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн 18 (18,94%) нь урт хугацааны нөлөөлөлд орж байна. Урт хугацааны нөлөөлөлд ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, геологийн тогтоцын өөрчлөлт, гадаргын нөөц баялаг, эрдэс түүхий эдийн нөөц, байгалийн унаган төрх өөрчлөгдөх ландшафтын өнгө төрх өөрчлөгдөх гэх мэт нөлөөллүүд хамаарна. Иймээс байгалийн унаган төрхийг алдагдуулсаны дараа эргүүлж нөхөн сэргийх ажлыг маш нарын дэс дараалалтай хийх шаардлагатай байна.

Нөлөөллийн эрчим. Ургамлын бүтэцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, эрдэс, түүхий эдийн нөөц хөрсний эвдрэл бохирдол зэрэг нь хүчтэй сөрөг нөлөөллөлд хамрагдаж байгаа учир байгаль орчныг хамгаалах төлвөлгөөнд энэ хүчтэй нөлөөлөлд орсон объектийг хэрхэн сэргээх талаар тодорхой тусган, үйдвэрлэлийн явцад мөрдлөг болгон ашиглахыг төслыг хэрэгжүүлэгчид

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

зөвлөж байна. Үүний зэрэгцээ хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх, агаарын бохирдол, бэлчээрийн байдал, ургамлын бүтцийн өөрчлөлт, гадаргын нөөц баялаг, байгалийн унаган төрхийн өөрчлөлт, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх орон нутгийн орлого нэмэгдэх, ядуурлыг бууруулахад дэмжлэг болох, шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс борж хөрс эвдрэх, ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй муухай үнэр гарах, шавж үржих, хүчтэй салхи, уруйн үер зэрэгт эрчимтэй нөлөөлнө. Учир нь байгаль орчны хүчин зүйлүүд нь өөрөө нөхөн сэргэх чадвар маш муу байдаг.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт байрлах “Дэлгэрхааны хайлуур жоншны ордын өмнөд хэсгийг ил, далд аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн технологи ажиллагааны онцлогтой нь уялдуулан ОУ-ын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох арга, аргачлалын дагуу байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тус бүрд нь авч үзсэний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах бусад багц хууль, холбогдох журам, зааврын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй төслийн хэрэгжилтийн үе шатанд байгаль хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр нь бууруулж нөхөн сэргээх зорилтыг хангах үүрэгтэй юм.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тусгасан байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлж, тухайн жил бүр мөрдөн ажилладаг байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оршино.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь төслийн төгсгөлийн ажлын үе шатанд байгаль орчинд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, зардал, хариуцах эзний хамтаар төлөвлөн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахад чиглэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт:

- Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөж ажиллах
- Нутгийн ард иргэдийн уламжлагдаж ирсэн соёл, өв уламжлалыг хүндэтгэж хамгаалах;
- Цаашид ашиглах шаардлагагүй хөндөгдсөн талбайнуудыг тухай бүрд нөхөн сэргээж, орон нутагт хүлээлгэж өгөх;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, компанийн чадамжийн хэмжээнд хувь нэмрээ оруулах;
- Батлагдсан БОМТ 2024-г хамгийн багадаа 90%-ийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэх;
- Хүрээлэн буй орчны талаар ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх;
- Байгаль орчны мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;
- Төрийн захиргааны байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хяналт шалгалт, БО-ны аудитаас гарах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган 2024 онд хэрэгжүүлэх байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар						
1	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслог тогтоосон хугацаанд нь сольж байна.	Уурхайн хэмжээнд		Мот/цаг Уулын ажлын төсөвт орсон	Үйл ажиллагаа эхлэхэд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
2	Уурхайн замын сүлжээг оновчтой төлөвлөх, тоосжилт ихтэй үед замуудыг услах	Уурхайн хүрээнд	-	2000.0	Үйл ажиллагаа эхлэхэд	- MNS 4585:2016 MNS 3384:82 MNS 4885:2007
3	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Уулын ажлын төсөвт орсон	Үйл ажиллагаа эхлэхэд	Агаарын тухай хууль
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч						
4	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд		Дотоод үйл ажиллагааны зардалд	2024 онд	Газрын тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх
5	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын талбай, авто зогсоол		500,000	2024 онд	тухай хууль MNS 5916:2008

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
6	Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Уурхайн хэмжээнд		500,000	2024 онд	MNS 5917:2008 MNS 5918:2008
Ургамлан нөмрөг						
7	Олон салаа зам гаргахгүй байна.	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	Дотоод үйл ажиллагааны зардалд		2024 онд	Амьтны тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
8	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн хотхонд		500,000	2024 онд	
9	Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Уурхайн зам, уурхайн хил хязгаар		1000,000	2024 онд	
10	Автомашинны зогсоолыг хайргаар хучих	Засварын талбай, зогсоол		500,000	2024 онд	
11	Шимт хөрсний овоолго үүсгэж, ургамалжуулж хадгалах	Уурхайн хэмжээнд		1000,000	2024 онд	
Усан орчин						
12	Сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулан төлбөрөө төлнө	Төслийн хүрээнд	Дотоод үйл ажиллагааны зардалд		2024 онд	Усны тухай хууль MNS 0900:2018 MNS 4943:2015 MNS 5850:2008
13	Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулах		Үйл ажиллагааны зардалд орно		Үйл ажиллагаа эхлэхэд	
14	Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахиж ажиллана.	-		1000.0	-	
15	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Уст цэгт	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон		2024 онд	
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал						7000,000

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус уурхай нь 2023-2027 он хүртэлх 5 жилийн хугацаанд нөхөн сэргээлтийн хүрээнд зөвхөн шимт хөрсний нөөц бий болгох, одоогийн шимт хөрсний чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх бөгөөд нөхөн сэргээлтийн ажил 2027 оноос эхлэхээр ТЭЗҮ болон БОННУ-нд тусгагдсан болно. Гар аргаар алт олборлогчдод өртсөн талбайд Уулын ажилтай зэрэгцэн маркшейдэрийн хэмжилт хийж нэмэлтээр нөхөн сэргээх газрын хэмжээг тооцоолно.

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Баянчулуут газар” ХХК нь дүйцүүлэн хамгаалах ажлаар БОННУ-ний тайланд тусгагдсан "Зэрлэг амьтан хамгаалах судлах нийгэмлэг" ТББ-ийн Хэнтий аймгийн Хурхын хөндийд хийгдэж байгаа нүүдлийн шувуу бөгжлөлийн судалгаа мөн ус намгархаг газрын амьдрах орчны судалгаа, хамгааллын судалгаанд хөрөнгө оруулах, Бэрхийн далд уурхайд хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа цаашдын төсөл хөтөлбөрүүдэд хамтарч ажиллахад зардлыг зарцуулахаар төлөвлөсөн ба Хэнтий аймгийн 0.4 га-аас ихгүй талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөж байна.

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээ -ний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэг-жийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	УАТ-ний дагуу байгаль орчны байцаагчаас санал авч дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлыг сум, орон нутагт хийж гүйцэтгэнэ.	2.5 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ.	Сумын нутаг дэвсгэрт	2.5 га	-	5000,000	2024 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
2	Төслийн талбайд 2024 онд 300 ш мод заасан чиглэлд тарихаар төлөвлөв	0.5 га талбайд	Төслийн талбайд	300ш	10,000	3000,000	2024 онд	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нийт зардал							8000,000	

**НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт байрлах Дэлгэрхааны хайлуур жоншны ордын өмнөд хэсгийг ил, далд аргаар ашиглах төслийн талбай болон түүний орчимд одоогоор түүх, соёлын өв, дурсгалт олдвор тэмдэглэгдээгүй (“Баян чулуут газар” ХХК-ийн “Дэлгэрхаан” хайлуур жоншны ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн) бөгөөд хэрвээ тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай Батноров сумын, засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах болно.

Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал, олдвор	Төслийн барилга байгууламжийн ажлын үед болон уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж байх үед соёлын биет өв илэрвэл төсөл хэрэгжүүлэгч нь ажлаа зогсоож, Энэ тухай сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад мэдэгдэх.	Төслийн талбай	2024 онд соёлын биет өв илэрсэн тохиолдолд	Соёлын өвийн тухай хуулийн 38.3
2	Палеонтологийн дурсгал, олдвор				
Сургалт сурталчилгааны зардалд					1000,000 төг

Сургалт сурталчилгааны зардалд 1 000,000 төгрөг төсөвлөсөн.

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АРАВ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Дэлгэрхааны хайлуур жоншны ордын өмнөд хэсгийг ил, далд аргаар ашиглах” төслийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн осол гарч болзошгүй бөгөөд гол төлөв хүмүүсийн өөрсдийнх нь үйл ажиллагаанаас үүдэн гардаг. Энэ нь машин техник, тоног төхөөрөмжүүдтэй харьцаж ажиллах зэрэг бүхий л үйл ажиллагаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйл ажиллагааны хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга Хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал сая. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<i>Байгалийн гаралтай осол эрсдэл</i>					
Байгалийн гамшгийн улмаас ажилчдын эрүүл мэнд, техник тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарч болзошгүй	Хүчтэй салхи шуурга, аянга цахилгаантай бороо орох үед үйл ажиллагааг түр зогсоох	Төсөл хэрэгжих бүс	Үйл ажиллагааны зардал	2024 он	Гамшгаас хамгаалах тухай хууль
	Гэнэтийн осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт зохион байгуулах	Төслийн талбай		2024 он	
<i>Нийгмийн гаралтай осол эрсдэл</i>					
Болзошгүй осол, саатал, техник тоног, төхөөрөмжийн гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, бүртгэл хөтлөх	Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж, техник	Үйл ажиллагааны зардал	Төслийн өдөр тутмын үйл ажиллагаа	Гамшгаас хамгаалах тухай хууль
Төслийн талбайд цахилгаан үүсгүүр болон тамхины цог зэргээс гал түймэр гарч болзошгүй.	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах болон галын хорыг байнга шалгах, цэнэглүүлэх	Төсөл хэрэгжих бүс	1500,000	2024 онд	

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ДЭЛГЭРХААНЫ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН ӨМНӨД ХЭСГИЙГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга Хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал сая. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
